



**Монгол улсад Байгаль орчин, Орон нутгийн иргэд, Хүний Эрхийг Хамгаал -
ФОРУМ АЗИ болон ХЭХТ-өөс Монгол улс дахь хүний эрхийн зөрчлийн
нөхцөл байдалд хийсэн үнэлгээний тухай МЭДЭГДЭЛ**

Хүний эрх, хөгжлийн Азийн форум (ФОРУМ-АЗИ), гишүүн байгууллага Хүний эрх хөгжил төв (ХЭХТ)-тэй хамтран 2019 оны 5-р сарын 5-10-ны өдрүүдэд Монгол улсын зүүн аймгуудад хүний эрхийн зөрчлийн нөхцөл байдалд үнэлгээ хийн баримтжуулав. Үнэлгээг Хэнтий болон Дорнод аймгийн дөрвөн сумд хийлээ.¹ Зорилго нь байгаль орчин, хүний эрхийг хамгаалагчид болон орон нутгийнханд уул уурхайн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх байв. Үнэлгээ хийх явцад бид гол оролцогч талууд болох уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлага, хүний эрхийг хамгаалагчид, орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй уулзаж ярилцсан. Энэхүү үнэлгээ нь ФОРУМ-АЗИ байгууллагаас 2012 онд Монгол улсад хийсэн өмнөх үнэлгээний үргэлжлэл юм.²

Нөхцөл байдлын үнэлгээний явцад ФОРУМ-АЗИ болон ХЭХТ уул уурхайн дотоодын компаниуд Биндэр болон Батширээт сумдын нутагт голын ай сав газарт үйл ажиллагаа явуулж байгааг олж тэмдэглэв. Голын ай сав газарт явуулж буй үйл ажиллагаа нь ус, хөрсийг бохирдуулан байгаль орчныг сүйтгэж, орон нутгийн иргэдийн аж амьдралд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгаад ихэд санаа зовниж байна. Болзошгүй аюул гэж тооцогдож байгаа хэдийч орон нутгийн засаг захиргаа болон иргэд уул уурхайн үйл ажиллагаа бүрэн эхлээгүй байхад ус болон хөрсний чанар муудан, агаарын бохирдол нэмэгдсэн ба байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад олон нийтийн бодит оролцоог хангахгүй байгаа талаар ярьж байсан болно. Монгол улс нүүдлийн соёлтой улс бөгөөд малчдын үе удмаараа ашиглаж ирсэн бэлчээрийн газарт уурхайн үйл ажиллагаа давхцан газар нутгийн асуудал үүссэн тухай хэд хэдэн тохиолдлыг нөхцөл байдлын үнэлгээний явцад баримтжуулсан.

Байгаль орчин болон хүний эрхийн асуудлын хувьд гар аргаар олборлолт явуулдаг “нинжа”³ нарын үйл ажиллагааг тулгарч буй томоохон асуудал гэж тодорхойлсон болно. Албан ёсны зөвшөөрөлгүй олборлолт хийдэг “нинжа” нар нь уул уурхайтай холбоотой бүх зохицуулалтыг зөрчиж байна. Нөхцөл байдлын үнэлгээгээр “нинжа” нар нь Батноров сумын бэлчээрийн талбайд олон тооны том нүх ухан байгаль орчинд ихээхэн хохирол учруулсныг баримтжуулсан болно. “Нинжа” нарын хууль бус үйл ажиллагааг зогсоохыг оролдож буй орон нутгийн удирдлагуудыг тэд дайрч доромжилсон, биед нь халдсан зэрэг тодорхой үйлдлүүдийг баримтжуулав. “Нинжа” нарын үйл ажиллагаа нь байгаль орчныг сүйтгэх, хүний эрхийг зөрчихөөс гадна ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлын тод илэрхийлэл юм. Ажилгүйдэл, ядуурлаас болж олон иргэд ийм эрсдэлтэй алхам хийхэд хүржээ.

Талууд авилгын талаар мэдээлж байв. Үнэлгээний багийн гишүүдэд гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулинд заасны дагуу хориглосон зарим газарт уул уурхайн үйл ажиллагааг эхлүүлээд байгаа тухай мэдээлж байв. Орон нутгийн удирдлагууд ашиглалтын зөвшөөрлийг үргэлжлүүлэн өгсөөр байна. “Нинжа” нар орон нутгийн удирдлага үзлэг шалгалт хийх тухай мэдээллийг ихэнхдээ урьдчилан авч зугтан хариуцлагаас мултардаг байна.

¹Томилолтоор ажилласан газрууд:

- a. Хэнтий аймаг: Биндэр, Батширээт, Батноров сумдууд, Чингис хаан хот;
- b. Дорнод аймаг: Цагаан-Овоо сүм

²<https://www.forum-asia.org/?p=15662>

ФОРУМ-АЗИ болон ХЭХТ-ийн томилолтоор ажилласан орон нутгуудад уул уурхайн ажиллагааг дэмжсэн болон эсэргүүцэж байгаа эсрэг тэсрэг байр суурь нэгэнтээ тогтон орон нутгийн иргэдийг улам талцуулан хувааж байгааг бид томилолтын явцад олж тогтоосон. Тухайлбал, Цагаан-Овоо сумын хувьд уул уурхайн ажиллагааг дэмжиж байгаа орон нутгийн иргэдэд алтны уурхайн компани оюутны тэтгэлэг олгосон гэсэн ам яриа байсан.

Нөхцөл байдлын үнэлгээний багийн гишүүд уул уурхайн олборлолтыг эсэргүүцэж буй орон нутгийн хүний эрхийг хамгаалагчдыг хэл амаар доромжлох, бие махбодыг нь гэмтээх, эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдад бэлгийн дарамт үзүүлэх нь олонтай тохиолдож байгааг баримтжуулсан болно. Мөн хүний эрхийг хамгаалагчдын гэр бүлийн гишүүд болон хамаатан садныг айлган сүрдүүлэх тохиолдлуудыг баримтжуулсан юм. Хүний эрхийг хамгаалагчдыг ихэнхдээ хэл амтай, хэрүүл маргаан дэгдээгч гэж үздэг төдийгүй гэр бүлийн гишүүдийн зүгээс хүний эрхийг хамгаалах ажлаа зогсоохыг шаардсан дарамт шахалт үзүүлэх нь цөөнгүй байна.

Олж авсан баримтуудыг харгалзан үзсэний үндсэн дээр Монгол улсын Засгийн Газрыг Хүний эрхийг хамгаалагчдын хуулийг баталж хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, хүний эрхийг хамгаалагчдыг айлган сүрдүүлсэн хэргүүдийг шуурхай, шударга, хараат бусаар мөрдөн шалгахыг юуны өмнө уриалж байна. Засгийн Газар гэм буруутай этгээдүүдэд зохих хариуцлагыг хүлээлгэх ёстой. Аливаа бизнесийн үйл ажиллагаа, ялангуяа уул уурхайн үйл ажиллагаа нь тухайн улсын хууль тогтоомж, бодлого, НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн талаар мөрдөх зарчмууд зэрэг олон улсын хүний эрхийн стандартын дагуу хэрэгжиж байгааг Засгийн Газраас хянах ёстой. Засгийн Газар “нинжа”-нуудын олборлолт хийх болсон нийгэм эдийн засгийн суурь шалтгааныг арилгах тодорхой алхам хийхийн зэрэгцээ бичил уурхай эрхлэх шаардлага хангасан эрх зүйн орчинг бүрдүүлж, хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Бид, Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад ус, хөрсийг бохирдуулан байгаль орчныг сүйтгэхээс сэргийлж, орон нутгийн иргэдийн амьжиргаа, соёл, ёс заншил, хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байхыг уриалж байна. Мөн уул уурхайн сөрөг нөлөөллийг эсэргүүцэж буй хүний эрхийг хамгаалагчдад ямар нэг байдлаар дарамт шахалт үзүүлэхгүй байхыг уул уурхайн компаниудаас шаардаж байна.

ФОРУМ-АЗИ болон ХЭХТ үнэлгээний явцад багий гишүүдтэй ярилцахыг зөвшөөрсөн бүх оролцогч талуудад талархлаа илэрхийлж байна. Оролцогч талуудад өгөх зөвлөмж бүхий эцсийн тайланг 2019 оны хоёрдугаар хагаст олон нийтэд хүргэх болно. Энэхүү тайланг 2020 оны 6-р сард Монгол улс дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илтгэл тавих НҮБ-ын Тусгай Илтгэгчид хүргүүлэх болно.